



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/9

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улс дахь Оросын Холбооны Улсын өмчийн маргаантай асуудлыг шийдвэрлэх хоёр дахь шатны ажлын жагсаалтад орсон Дархан-Уул, Орхон, Дорнод аймаг дахь газар, үл хөдлөх хөрөнгийн талаар ОХУ-ын талын ажлын хэсэгтэй хамтран үзлэг хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ахлагч: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл

Гишүүд: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн М.Баярмаа

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч Л.Гансүх /зөвшилцсөнөөр/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн жолооч Х.Базаррагчаа


2. Албан томилолтын зардлын төсвийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу холбогдох эх үүсвэрээс гаргаж зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (Ц.Гантуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн ажлын 5 хоногт багтаан хийж гүйцэтгэн, тайланг танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



132003010

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын  
2023 оны 01 сарын 13 ны өдрийн 1/6 дугаар тушаалын  
Нэгдүгээр хавсралт

ОРСН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭГДЭХҮҮН, ЗАРДЛЫН ТӨСӨВ

(төгрөгөөр)

Д/д	Аймгийн нэр	Ажлын хэсэг		Ажиллах хүний тоо	Ажиллах хоног /кален	Томилолтын зардал	Замын зардал /шатахуун/	Нийт зардал
		Нэр	Албан тушаал					
	<b>Дархан, Орхон, Дорнод</b>							
1	Дархан-Уул	Д.Нарангэрэл М.Баярмаа Х.Базаррагчаа	ТӨБАХ-ийн дарга, мэргэжилтэн, жолооч	3	1	426,000.00	81,000.00	507,000.00
2	Орхон			3	2	852,000.00	234,000.00	1,086,000.00
3	Дорнод			3	2	708,000.00	482,400.00	1,190,400.00
	<b>дүн</b>				<b>5</b>	<b>1,986,000.00</b>	<b>797,400.00</b>	<b>2,783,400.00</b>

**Танилцсан:**

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Н.Ганболд

**Хянасан:**

Ерөнхий нягтлан бодогч

Ц.Гантуяа

**Боловсруулсан:**

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

М.Баярмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 01 дүгээр сарын 13 өдрийн  
1/9 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Оросын Холбооны Улсын өмчийн хоёр дахь шатны объектын жагсаалтад орсон газар талбайн хамтарсан үзлэг шалгалтыг зохион байгуулах, үл хөдлөх хөрөнгийн акт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ОХУ-ын талын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. Дархан-Уул, Орхон аймагт байгаа ОХУ-ын Ерөнхий консулын газрын ашиглалтад байгаа газар түүний дээрх үл хөдлөх хөрөнгийн цогцолборын бодит байдалд үзлэг, тооллого, хэмжилт хийж, акт үйлдэж баталгаажуулна. /фото зураг, видео бичлэг хийх, маягт мэдээлэл бэлтгэх/

2. Үл хөдлөх хөрөнгийн чанар байдал, улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах баримт материалын бүрдэлийг хангана.

3. Үзлэг, тооллого, хэмжилтийн дүнгээр тайланг бэлтгэж акт үйлдэн хамтарсан Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулахад бэлтгэнэ.

-----000-----